

**"УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТУХАЙ" МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Тогтоолын төслийн нэрийн "хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар" гэснийг "хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар" гэж өөрчилж, төслийн тэмдэглэх хэсгийн "Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг," гэснийг тус тус хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

2.Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын "хугацаандаа" гэсний өмнө "эсхүл бусад шалтгаанаар" гэж нэмж, "тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу" гэснийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

3.Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын "2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор" гэснийг "Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд " гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

4.Тогтоолын төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"2/Энэ тогтоолын 1.1 дэх дэд заалтад заасан тайланд тусгагдсан төсөл, арга хэмжээг хуульд заасан өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх, эсхүл хууль зүйн тодорхой үндэслэлтэйгээр цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх эсэх саналаа энэ тогтоолын 1.1-д заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;"

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

5.Тогтоолын төслийн 1.3 дахь дэд заалтыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

6.Тогтоолын төслийн 1.4, 1.5 дахь дэд заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"3/Улсын Их Хурлаар жилийн төсвийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлгийн бүх шатанд Төсвийн тухай хуулийн 29¹.4-т заасан цахим систем дэх мэдээллээс улсын

төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг Улсын Их Хурлын гишүүд нээлттэй харах боломжийг бүрдүүлэх."

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

7.Тогтоолын төслийн 2, 3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 4 дэх заалтын дугаарыг "3" гэж өөрчлөх:

"2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо/Н.Наранбаатар/-нд даалгасугай."

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

8.Найруулгын санал:

Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын "хуульд тусгаж" гэснийг "хуулиар баталж" гэж, "анх батлагдсан" гэснийг "анхны" гэж, "буй ачаалал, дарамт" гэснийг "байгаа нөлөөлөл" гэж, "бүрээр тус бүр үнэлж " гэснийг "нэг бүрээр судалж " гэж тус тус өөрчилж, мөн дэд заалтын заалтын "талаар судалж," гэснийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын "зогссон" гэсний дараа ", анхны төсөвт өртөг нь 50-аас дээш хувиар нэмэгдсэн," гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл

---oOo---